



ДУНДГОВЬ АЙМАГ
ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 14

Цагаан-Овоо

Сум хөгжүүлэх сангийн зээлийн
дээд хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Сум хөгжүүлэх сангаас тухайн жилд олгох төслийн зээлийн дээд хэмжээг дараах байдлаар тогтоосугай.

№	Олгох чиглэл	Дээд хэмжээ
1	Иргэн /сая төг/	20,000,000
2	Хуулийн этгээд /сая төг/	50,000,000

Хоёр.Нэг төсөлд олгох зээлийн хэмжээг дээрх хязгаараас хэтрүүлэхгүй, батлагдсан чиглэлийн дагуу олгож орон нутагт жижиг үйлдвэрийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлж ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн дарга /Б.Өлзийхишиг/-т үүрэг болгосугай.

Гурав.Энэ тогтоол гарсантай холбогдуулан холбогдуулан 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 44 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Ц.Алдармаа/-д даалгасугай.

ДАРГА

Ё.ДАРЬСҮРЭН



4301100010